

**Б.Одонгэрэл. Хууль зүйн доктор, дэд профессор.
СИТИ Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал
И-мэйл: odongerebira@gmail.com**

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХОХИРОЛ ХОР УРШИГТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

Түлхүүр үг: хууль бус ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, химийн хорт аюултай бодис, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, давхар хариуцлага, ялын үр нөлөө, хохирол, хор уршиг

ХУРААНГУЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХ ЯВДАЛ МОНГОЛ УЛСАД ТӨДИЙГҮЙ ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН НЭГ БОЛСООР БАЙНА. ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРЧ БУЙ ХОХИРОЛ, УРШГИЙН ХЭМЖЭЭ Ч БУСАД ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХАРЬЦУУЛАХАД ӨНДӨР БАЙГААГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ИЙМД ЭНЭХҮҮ ИЛТГЭЛЭЭР БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ХЭРЭГ МАРГААНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗАМААР ЦААШИД АНХААРАХ АСУУДЛЫГ ИЛРҮҮЛЭН, ОНОЛ ПРАКТИКТ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМЫГ НЭЭН ИЛРҮҮЛЭХЭЭР ЗОРИЛОО. ЯЛАНГУЯА ХАМГИЙН ӨНДӨР ХОХИРОЛ, ХОР УРШИГ УЧРУУЛЖ БУЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ, ХИМИЙН ХОРТ АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ, ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭСЭН 3 ТӨРЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШИЙТГЭХ ТОГТООЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ ЭНЭХҮҮ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДСЭН ХЭСЭГ НЬ БОЛСОН ЮМ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭР БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ОНОГДУУЛЖ БУЙ ЯЛЫН ХЭМЖЭЭ БАГА, ҮҮНИЙ УЛМААС ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ, ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА ДУУССАН ҮНДЭСЛЭЛЭЭР ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОЖ БУЙ ПРАКТИК ТҮГЭЭМЭЛ, ЗӨРЧИЛ ГЭМТ ХЭРГИЙГ ЯЛГАХГҮЙ ЗӨРЧЛӨӨР ШИЙДВЭРЛЭХ, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХУВЬ ХҮНИЙГ ЯЛ ЗАВШУУЛАХ, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛӨЛТ МУУТАЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ТАЛААРХ ХУУЛЬЧДЫН ОНОЛЫН МЭДЛЭГ, ТУРШЛАГА БАГА БАЙНА ГЭДЭГ НЬ ИЛЭРЛЭЭ. ЭЦЭСТ НЬ ЭНЭХҮҮ ӨГҮҮЛЛЭЭР ЦААШИД ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ САНАЛ, ДҮГНЭЛТИЙГ ДЭВШҮҮЛЭН ТАВЬЛАА.

ТОВЧИЛСОН ҮГ:

ШЕЗ- ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ХХК- ХАРИУЦЛАГАТАЙ ХЯЗГААРЛАГДМАЛ КОМПАНИ
ТББ- ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
АНУ- АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС
UNODC- UNITED NATIONS OFFICE ON DRUGS AND CRIME

УДИРТГАЛ

Хүн төрөлхтний оршин тогтнох өлгий болсон байгаль дэлхийгээ танин мэдэж, түүний нөөц баялгийг зүй зохистой ашиглахын зэрэгцээ нөхөн сэргээж хайрлан хамгаалах нь дэлхий нийтийн амин чухал асуудлын нэг билээ. Монгол Улс уул уурхайн олборлолт хийснээс хойш байгаль орчинд ноцтой хохирол учруулсан гэмт хэрэг олноор үйлдэгдэх болсон. Хууль бус уул уурхайг ногоон түмпэн үүрсэн, хүрз жоотуу барьсан нинжагаар төсөөлөгддөг байсан нь сүүлийн арав гаруй жилийн хугацаанд нөхцөл байдал нэлээдгүй өөрчлөгджээ. Тодруулбал, энэ төрлийн гэмт хэргийг хүчин чадал өндөртэй экскаватор, ковш, ачигч ашиглан, зохион байгуулалттай бүлэг, хуулийн этгээдүүд ихээр үйлдэх болжээ. Шинжлэх ухаан, техник, технологи эрчимтэй хөгжиж, үйлдвэржүүлэлт, аж ахуй эрхлэлт эрчимжиж хотжилт, хүн амын төвлөрөл ихсэж буй өнөө үед байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах, сөргөөр нөлөөлөх хор уршиг гарсаар байгаа нь хүрээлэн буй орчин, түүний зохицолт байдлыг хангах, хамгаалах явдал нь тулгамдсан асуудал болжээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд байгаль орчны тэнцвэрийг хадгалах, усны нөөцийг хамгаалах, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын ховордлоос сэргийлэх нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс хэмээн заасан билээ. Монгол Улс байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэхдээ нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийн хүрээнд амьдралын хэрэгцээг бүрэн хангах, үл нөхөгдөх буюу удаан сэргэдэг нөөцийг гагцхүү улс орны хөгжлийн нэмэлт хүчин зүйл болгон зохистой ашиглах замаар экологийн аюулгүй байдлыг хангах явдлыг чухалчилна хэмээн төрөөс экологийн талаар баримтлах бодлогод тодорхойлжээ.

Олон улсад ч Биологийн олон янз байдлын тухай НҮБ-ын конвенц, Дэлхийн соёлын ба байгалийн өвийг хамгаалах тухай конвенц, Био-аюулгүй байдлын тухай Картагенийн Протокол зэрэг олон баримт бичигт хүн төрөлхтний үнэт өв болох байгаль дэлхийг хайрлан хамгаалах талаар тунхаглаж, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тууштай тэмцсээр ирсэн.

Тавин жилийн өмнө жилдээ хүн төрөлхтөн нэг сая тонн химийн бодис үйлдвэрлэж байсан бол өнөөдөр 400 сая тонн болтлоо нэмэгджээ. Мөн 100 орчим мянган нэр төрлийн химийн бодисыг улс хооронд худалдаалж, жилдээ 1000 орчим нэр төрлийн химийн бодисыг шинээр нээж байна. Монгол Улсад тухайлбал, Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан химийн хорт бодисыг хууль

бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн тухайд 2018-2021 оны хооронд 53 хэрэг шүүхээр шийтгэгджээ. Өнөөдөр дэлхийд ашиглагдаж байгаа 11 сая орчим нэр төрлийн химийн бодисоос 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхэд нь эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байгаа. Түүнчлэн иргэд болон гар аргаар алт олборлогчид алтны баяжмалтай шороог химийн хорт бодис болох мөнгөн ус ашиглан угаах, химийн хорт, аюултай бодисыг тээврийн хэрэгсэлд нуун хилээр оруулж ирэхийг завдсан тохиолдлууд жил ирэх тутам нэмэгдсээр байгааг анхаарахгүй орхиж болохгүй.

Иймд хүн төрөлхтөн амьдран орших мөнхийн тулгуур болсон байгаль дэлхийг хамгаалах эрх зүйн орчинг үнэлэх, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй үүднээс энэхүү өгүүллийг бичлээ.

Өгүүллээр дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг, Хууль бусаар мод бэлтгэх зэрэг байгаль орчны эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;
2. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэн хувь, хуулийн этгээдийн учруулж буй хохирол, хор уршгийн хэмжээ, онцлогт дүгнэлт хийх;
3. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдэж буй хувь, хуулийн этгээдэд оногдуулж байгаа ялын хэмжээ, түүний үр нөлөөнд шүүхийн шийдвэрт үндэслэн дүн шинжилгээ хийх;
4. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээд болон тус гэмт хэргийг үйлдсэн хувь хүнд хамтад нь ял оногдуулсан байдал буюу давхар хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтад дүгнэлт хийх;
5. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн эрх зүйн орчинг сайжруулахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид боловсронгуй болгох онол, практикын ач холбогдолтой санал боловсруулах.

Энэхүү өгүүлэлд дэвшүүлсэн зорилтуудыг хангахын тулд дараах судалгааны арга зүйг баримтална.

1. Баримт бичгийн шинжилгээний арга: Судалгаанд холбогдох баримт бичгүүдэд дараах байдлаар дүн шинжилгээ хийнэ. Үүнд: 2018 -2021 оны хооронд болон 2022 оны байгаль орчны эсрэг гэмт хэргийн статистик мэдээ, шүүхээр хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн мэдээ, түүний өсөлт бууралт, шийдвэрийн онцлогт дүн шинжилгээ хийхэд баримт бичгийн шинжилгээний арга ашиглана.

2. Кейс судалгааны арга: Монгол Улсад 2018 оноос хойш шүүхээр шийдвэрлэгдсэн нийт гэмт хэргээс түүвэрлэн авч, тэдгээрийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийнэ.

3. Харьцуулалтын арга: Олон улсын болон гадаадын сайн туршлага, өмнө судлагдсан судлаачдын бүтээлээс харьцуулан шинжилнэ. Мөн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхдээ анализын болон синтезийн аргыг түлхүү ашиглана.

Нэг. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг хуульчилсан ба дээрх бүлэгт 24.1 дүгээр зүйл. Байгаль орчин бохирдуулах, 24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал ашиглах, олборлох, 24.3 дугаар зүйл. Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах, 24.4 дүгээр зүйл. Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах, 24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах, 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх, 24.7 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр тавих гэмт хэрэг, 24.8.1 дүгээр зүйл. Байгалын ургамлыг хууль бусаар бэлтгэх, 24.9 дүгээр зүйл. Байгалын тэнцэл алдагдуулах гэсэн 9 төрлийн гэмт хэргийг багтаасан.

Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, байгаль хамгаалах журамд гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.1 дүгээр зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.


Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-д "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалын тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" Байгаль

орчныг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д "... хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүй үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах..." гэж хуульчилсан. Иймд байгаль орчныг бохирдуулах гэмт хэргийн үндсэн шинж нь халдлагад өртөгчийн амь нас, эрүүл мэндэд хихрол учирсан байхыг шаардахгүй, химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд хаяж, хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөл бүрдүүлснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Байгаль орчны эсрэг гэмт хэргийг үйлдэх субъект нь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай хувь хүн байхаас гадна хуулийн этгээд энэ төрлийн гэмт хэргийг үйлддэг. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө уг гэмт хэргийг үйлдсэн бол хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ. Иймд байгаль орчны эсрэг буюу Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах, Хууль бусаар мод бэлтгэх 3 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй онцлогийг судлах нь зүйтэй.

Байгаль орчны гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 24.1-24.9 хүртэлх нийт 9 гэмт хэргүүд байна. Үүнийг шинжлэн авч үзэхэд дараах байдалтай байна.

Figure 1. Types and current situation of Environmental crime




Дээрх зургаас үзвэл 2022 онд Монгол Улсад 1425 хэрэг шүүхээр хянан шийдвэрлэснээс 24.6 дүгээр зүйл буюу Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгджээ. Үүний дараагаар 24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал ашиглах, олборлох, 24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах, 24.8.1 дүгээр зүйл. Байгалын ургамлыг хууль бусаар бэлтгэх, 24.3 дугаар зүйл. Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг гэсэн эхний 5 гэмт хэрэг байна. Харин хамгийн цөөн үйлдэгдэж буй хүрээлэн буй орчны гэмт хэрэг нь 24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах, 24.7 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр

тавих гэмт хэрэг бол 24.4 дүгээр зүйл. Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэрэг, 24.9 дүгээр зүйл. Байгалын тэнцэл алдагдуулах гэсэн 2 төрлийн гэмт хэрэг 2022 онд Монгол Улсад огт үйлдэгдээгүй байна.

ЦЕГ-ын байгаль орчны эсрэг гэмт хэргийн тоон мэдээг сүүлийн таван жилийн байдлаар авч үзвэл 2013 онд 337, 2014 онд 287, 2015 онд 228, 2016 онд 165, 2017 онд 330 хэрэг, 2018 оны эхний 4 сард 113 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51-ээр буюу 45,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Figure 2. Ups and downs of Environmental crime



Хоёр. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг нь (Environmental crime) олон улсад учруулж буй хохирлын хэмжээгээрээ хууль бус эмийн худалдаа, хуурамч мөнгө үйлдвэрлэх, хүн худалдаалах гэсэн гэмт хэргүүдийн араас 4 дүгээрт орж буй гэмт хэрэг юм. Жилд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж 110-281 тэрбум долларын хууль бус ашиг орлого олохын зэрэгцээ хэдэн зуун тэрбумын хохирол, хор уршигийг хүн төрөлхтөнд учруулж байна. Хохирогчгүй гэгдэх энэ төрлийн гэмт хэрэг нь төрийн зүгээс анхаарах асуудлын жагсаалтын дээгүүр байр суурь эзэлдэггүй хэдий ч нийгэмд маш их хохирол учруулдагийг нь UNODC-ын тайланд дурджээ. Тухайлбал, хууль бус мод бэлтгэх гэмт хэрэг олон оронд ойгүйжилт бий болгож байна.

Хүрээлэн буй орчны гэмт хэргийг олон улсад хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэх нь түгээмэл бөгөөд хуулийн этгээдийн зүгээс учруулж буй

энэ төрлийн гэмт хэргийн хохирол хэдэн зуун тэрбум доллараар үнэлэгдэж буйг дээр өгүүлсэн. Монгол Улсад ч хүрээлэн буй орчны эсрэг 24.2, 24.3, 24.6 гэсэн 3 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай байна. Тухайлбал, 2022 онд 10 хуулийн этгээд шүүхээр гэм буруутай нь тогтоогдож, эрүүгийн хариуцлага хүлээсэн байна. Эдгээр 10 хуулийн этгээдийн 8 нь ХХК, 1 нь хувьцаат компани, 1 нь нөхөрлөл гэсэн төрөлтэй бөгөөд ТББ байхгүй байна.

Экологийн цагдаагийн албаны мэдээллээр хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэгт олон тооны хуулийн этгээд шалгагдсан, мөн шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн 86 хувьд өндөр хүчин чадалтай машин механизм ашигласан байгаа нь нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг харуулж байна. Хууль бус уул уурхайг дагалдан бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх, хүний эрх зөрчигдөх, амь нас, эрүүл мэнд хохирох, байгаль

орчин сүйдэх, бохирдох сөрөг үр дагавар үүсдэг. Хариуцлагагүй уул уурхайн компаниудын улмаас Монгол Улсад 20 гаруй мянган га газар нөхөн сэргээгдээгүй байгаа бол хууль бус уул уурхайн улмаас 8 орчим мянган га газар буюу эрүүл хөрс, гол горхи, ой мод сүйджээ.

Энэхүү сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байгаа байгаль орчны эсрэг гэмт хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна. Түүнчлэн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирч буй хохирлын хэмжээ нь 14 тэрбум байгаа бол үүнээс хуулийн этгээдийн учруулсан хохирол 10 тэрбум бол хувь хүний учруулсан хохирол нь 4 тэрбум байна. Мөн хохирол нөхөн төлүүлсэн байдлыг судлахад 4 тэрбум төгрөгийн хохирол төлүүлсний 3.4 тэрбум төгрөгийн хохирлыг хуулийн этгээдийн зүгээс төлүүлжээ. Үүнээс үзэхэд хуулийн нийт шийдвэрлэвэл зохих хэрэгт маш бага хувь эзэлж байгаа мөртлөө учруулсан хохирлоороо нийт хэрэгтэй харьцуулахад нийт хохирлын 72 хувийг эзэлж байна. Энэ нь хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгт хуулийн этгээд бол онцгой субъект мөн болохыг харуулж байна. Иймд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйл. Хууль бус ашигт малтмал ашиглах, олборлох, 24.3 дугаар зүйл. Химийн хорт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах, болон 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх гэсэн 3 зүйл ангийг сонгон авах нь зүйтэй гэж судлаачийн зүгээс дүгнэлээ.

Гурав. Байгаль орчны эсрэг гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж байгаа шийдвэрт дүн шинжилгээ хийх нь

2018-2021 оныг хүртэл 4 жилийн хугацаанд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 1677 шүүхээр шийдвэрлэвэл зохих хэрэг байсан бол 2022 онд 1425 шийдвэрлэвэл зохих хэрэг байгаа нь байгаль орчны эсрэг гэмт хэрэг огцом өссөн тоон мэдээтэй байгааг харж болохоор байна.

Бидэнхэсэгт байгаль орчны гэмт хэргийн хамгийн түгээмэл үйлдэгдэж буй төрөл буюу 3 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдийн төрлийг шүүх тодорхойлохдоо ХХК, хувьцаат компани, нөхөрлөл, хоршоо, сан, төрийн бус байгууллага гэсэн хуулийн этгээдийн төрлөөр ангилсан ба үүнээс гэмт хэрэг үйлдэж байгаа ихэнх буюу 95 хувийг ХХК эзэлж байна. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийг хэнээр тогтоож байгаа, хуулийн этгээд болон гэмт хэрэг гүйцэтгэсэн хувь хүнд давхар хариуцлага хүлээлгэж байгаа эсэх, хохирол нөхөн төлсөн эсэх, ямар төрлийн ял, албадлагын арга хэмжээг оногдуулж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийхдээ Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг сонгон авлаа.

Кейс-1. Өмнөговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх "ЭШ" ХХК нь нөхөн сэргээлт хийх нэрийдлээр 2017 оны 09 дүгээр сард Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Даянгар гэх газар тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт явуулж, байгаль орчинд 6.251.126 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэргийг 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр шийдвэрлэсэн.

Тус шүүхээс шүүгдэгч Б.Г, Б.М нарыг цагаатгаж, "ЭШ" ХХК-ийг гэм буруутайд тооцсон хэдий ч Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн байна. Түүнчлэн "ЭШ" ХХК-иас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 35.000.000 /гучин таван сая/ төгрөгийг гаргуулж улсын орлогод оруулахыг шийдвэрлэжээ. Тус хэргийг Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хянан магадалж, 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Өмнөговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 2018/ШЦТ/184 дугаар шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож, "ЭШ" ХХК-нд холбогдох хэргийг өөр шүүх бүрэлдэхүүнээр дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах шийдвэрийг гаргасан.

Кейс-2. Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь шүүгдэгч хуулийн этгээд "Олонбаян" ХХК нь Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 5 дугаар багийн нутаг "Цагаан хороот" гэх газарт 2017 оны 09 дүгээр сард тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт явуулсны улмаас байгаль орчинд 6451900 төгрөгийн хохирол учруулсан гэх хэргийг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр шийдвэрлэжээ.

Шүүхээс шүүгдэгч хуулийн этгээд "Олонбаян" ХХК-ийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хуульд заасан Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг өөрийн үйлдлээр хангасан тул шүүгдэгч Б.С-ыг гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож, шүүгдэгч хуулийн этгээд "Олонбаян" ХХК-д Эрүүгийн хариуцлага хүлээлгэж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Иймд шүүгдэгч хуулийн этгээд "Олонбаян" ХХК-ийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан болон шүүгдэгч Б.С нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэргийн шинжийг үйлдлээр хангасан тул шүүгдэгч хуулийн этгээд "Олонбаян" ХХК-д ял оногдуулж, байгаль орчинд учирсан хохирол болон хуулийн этгээдэд хүлээлгэсэн

торгуулийн ялыг уг гэмт хэргийн гүйцэтгэгч шүүгдэгч Б.С нь төлж барагдуулах зүйтэй гэж шүүхээс шийдвэрлэсэн нь хуулийн этгээдийг хувь хүнтэй шууд адилтган үзсэн харагдаж байна.

"Олонбаян" ХХК-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан хорин мянган /20.000/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу хорин сая /20.000.000/ төгрөгөөр торгох ялыг нэг жилийн дотор хэсэгчлэн төлөх, газрын хэвлийд нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх эрхийг буюу хасахаар тус тус тогтоосон төдийгүй байгаль орчинд учруулсан хохирол зургаан сая дөрвөн зуун тавин нэгэн мянга есөн зуун /6.451.900 / төгрөгийг гаргуулж Байгаль орчин уур амьсгалын санд оруулахыг Нийслэлийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газарт даалгаж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс хэргийг магадлаад "Олонбаян" ХХК-ийг арван мянган /10000/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10.000.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нэг /1/ жилийн хугацаагаар хасах, торгох ялыг нэг жилийн дотор хэсэгчлэн төлөхөөр тус тус тогтоож өөрчилсөн байна.

Энэ нь давж заалдах шатны шүүх хуулийн этгээдэд оногдуулах торгуулийн хэмжээг нэг дахин багасгасан төдийгүй байгаль орчинд учруулсан хохирлыг төлүүлэх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж шийдвэрлэсэн нь харагдаж байна.

Кейс-3. Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2019 оны 03 дугаар сарын 25-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч хуулийн этгээд "Стандарт хайрга" ХХК-д холбогдуулсан хэргийг хянан шийдвэрлэжээ.

Улаанбаатар хотын ... хаягтай, газрын хэвлийн болон эвдэрсэн газрын техникийн, биологийн нөхөн сэргээлт явуулах эрхтэй тус компани нь Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бага баян 3 дугаар багийн нутагт Овоо шанд гэх газар нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахдаа хууль бусаар ашигт малтмал олборлож, байгаль экологид 13 сая төгрөгийн хохирол учруулжээ.

Хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл нь "Стандарт хайрга" ХХК-ийн гүйцэтгэх захирал ажилтай Г.Э нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хууль бусаар ашигт малтмал олборлож байгаль экологид хохирол учруулсан. Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд "Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан бол ... хуулийн этгээдийг тодорхой

төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ" гэж заасан нь тус гэмт үйлдэл нь хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлийн нэг болж байна. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 4 хэсэгт их хэмжээний хохирол учруулсан бол гэж заасан тул 50 сая төгрөгөөс доош хохирол учруулсан тохиолдолд тус зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ял оногдуулна.

Тус шүүх хэргийг шийдвэрлэхдээ давхар хариуцлагын зарчмыг баримталсан бөгөөд өөрөөр хэлбэл, гэмт үйлдлийг гүйцэтгэсэн Г.Э-д тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал ашиглах, олборлох гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэж, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ хэрэглэж, "Стандарт хайрга" ХХК-д мөн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тодорхой төрлийн үйл ажиллагаа буюу нөхөн сэргээлт явуулах эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, хорин мянган /20.000/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 20.000.000 төгрөгөөр торгох ял шийтгэжээ. Түүнчлэн 161 грамм алтыг улсын орлогод хураах шийдвэр гаргасан.

Кейс-4. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт хаягтай, төмрийн хүдрийг баяжуулах, экспортлох, машин тоног төхөөрөмж суурилуулалт, холбогдох засвар үйлчилгээг явуулдаг хуулийн этгээд "Жин Тай Хэ" ХХК-д холбогдох хэргийг шийдвэрлэв. Тус хуулийн этгээдийг Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр ажиллуулах явцдаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах" гэмт хэрэг үйлдсэн гэх хэргийг шүүх авч хэлэлцсэн.

Тус хуулийн этгээдийг 2011 онд БНХАУ-ын нэр бүхий 3 иргэн байгуулж, Монгол Улсад хууль ёсоор бүртгүүлж үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн байна. 2015 онд БНХАУ-ын Эрээн хотын Бө-Шин худалдааны компанид "Жи Тай Хэ" ХХК-ийг шилжүүлсэн ба энэ хугацаанд 4 удаа гүйцэтгэх захирал нь солигдсон бөгөөд 2016 онд одоогийн хууль ёсны төлөөлөгч болох Лю Гуо Хуйг гүйцэтгэх захирлаар томилсон.

"Жи Тай Хэ" ХХК нь хуулийн этгээдийн өмнөөс, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн үйлдлээр, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө төмрийн хүдэр баяжуулан экспортлох үйл ажиллагаа явуулах явцдаа мөнгөн усны хлоридын давс хэмээх Монгол Улсын химийн хорт бодисын жагсаалтад байх хорт

бодисыг хадгалж байсан нь баримтаар нотлогдсон тул шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар төмрийн хүдэр баяжуулах үйл ажиллагааг нэг /01/ жилийн хугацаатайгаар хасаж, тавин мянган /50.000/ нэгжтэй тэнцэх буюу 50.000.000 төгрөгөөр торгох шийдвэр гаргажээ. Торгуулийн ялыг нэг жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Харин тус үйлдлийг гүйцэтгэсэн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу давхар хариуцлагын зарчмыг хэрэгжүүлсэнгүй.

Тус хэрэг нь гадаадын 100 хувийн хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн анхны тохиолдол болсноороо онцлогтой бөгөөд олон гүйцэтгэх захирал солигдсон, үйлдсэн эзэн нь тодорхойгүй гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт үр нөлөөтэй болохыг харуулсан тохиолдол болсон гэж дүгнэж байна. Эзэмшигч нь Бө-Шин худалдааны компанид шилжсэн гэх боловч бүрэн эрх шилжүүлэх гэрээнд ВапЖи Юнь гэх хүн гарын үсэг зурсан ба энэ хүн нь одоо Бө-Шин худалдааны компанийн эрх бүхий этгээд хэвээр байгаа нь тодорхойгүй харагдаж байна. Мөн одоогийн гүйцэтгэх захирал Лю Гуо Хуй нь 2016 онд гүйцэтгэх захиралар томилогдохоос өмнө энэ бодис тус үйлдвэрт байсан гэж мэдүүлсэн нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд эрүүгийн хариуцлага оногдуулахад хүндрэл учруулж байна.

Дээрх хэргүүдийг дүгнэн үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйл буюу хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг нийт шийдвэрлэсэн гэмт хэргийн 50 хувийг эзэлж байна. Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй." гэж заасан ч нийт гэмт хэргийн дийлэнх нь давхар хариуцлагын зарчмыг баримтлаагүй, зөвхөн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Дүгнэлт

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг хуульчлагдан энэ төрлийн гэмт хэргийг шүүхээс эрүүгийн хариуцлага оногдуулж байна. Дэлхийд байгаль орчны эсрэг гэмт хэргийн тоон мэдээ өссөөр байгаа төдийгүй хохирол, хор уршгийн хэмжээгээр хууль бус эмийн худалдаа, хуурамч мөнгө үйлдвэрлэх, хүн худалдаалах гэсэн гэмт хэргүүдийн араас 4-р байранд орж байна. АНУ-д жилд байгаль орчны гэмт хэргийн улмаас 100 гаруй тэрбум долларын хууль бус ашгийг олохын зэрэгцээ хэдн зуун

тэрбумын хохирол, хор уршгийг учруулсаар байна гэж мэдээлжээ.

Монгол Улсын шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд 2018-2021 оныг хүртэл 4 жилийн хугацаанд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 1677 байсан бол 2022 онд 1425 шийдвэрлэвэл зохих хэрэг байгаа нь байгаль орчны гэмт хэрэг огцом өссөн тоон мэдээтэй байгааг харж болохоор байна.

Иймд манай улсад өсөн нэмэгдсээр байгаа хохирол хор уршгаараа дээгүүрт байгаа байгаль орчны гэмт хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд илэрч байна.

1. 2018-2021 оны 4 жилийн хугацаанд хүрээлэн буй орчны эсрэг нийт гэмт хэрэг 1425 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс дээрх 3 төрлийн гэмт хэрэг буюу 24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг 330, 24.3 дугаар зүйл. Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг - 53, 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг - 763 байгаа нь 1146 буюу нийт хэргийн 80 хувь байна.

2. Мөн түүнчлэн Монгол Улсад байгаль орчны гэмт хэргийн улмаас учирч буй бодит хохирлын хэмжээ нь 14 тэрбум байгаа бол үүнээс хуулийн этгээдийн учруулсан хохирол 10 тэрбум бол хувь хүний учруулсан хохирол нь 4 тэрбум байна. Мөн хохирол нөхөн төлүүлсэн байдлыг судлахад 4 тэрбум төгрөгийн хохирол төлүүлсний 3.4 тэрбум төгрөгийн хохирлыг хуулийн этгээдийн зүгээс төлүүлжээ. Үүнээс үзэхэд хуулийн нийт шийдвэрлэвэл зохих хэрэгт маш бага хувь эзэлж байгаа мөртлөө учруулсан хохирлоороо нийт хэрэгтэй харьцуулахад нийт хохирлын 72 хувийг эзэлж байна.

3. Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан байгаль орчны эсрэг хуулийн этгээдийн зүгээс үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэсэн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд байгаль орчны эсрэг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг болон химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийг компанийн зүгээс үйлдэж байгаа бөгөөд тэдний дийлэнх нь хөөн хэлэлцэх хугацаа дуусч хэрэгсэхгүй болох, гэмт хэргийг зөрчилд тооцон хөнгөн шийтгэл оногдуулах явдал түгээмэл байна.

4. Эрүүгийн хэргийн шүүхээс шийдвэрлэсэн 4 шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг

ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэсэн заалт буюу давхар хариуцлагын зарчим манай улсад жигд хэрэгжихгүй хуулийн заалт зөрчигдөж байна.

5. Түүнчлэн хуулийн этгээдэд оногдуулж буюу торгох ялын хэмжээ үр нөлөө багатай байна. Хуулийн этгээдийн зүгээс байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэний улмаас хэдэн зуун тэрбум хохирол, хор уршиг учирч байхад нөхөн төлүүлж буй хохирлын хэмжээ торгох ялын хэмжээ түүнээс маш бага байгаа нь хуулийн этгээдийг байгаль орчны эсрэг гэмт хэргээ үргэлжлүүлсээр байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд байгаль орчны эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлтэд анхаарч ялангуяа хуулийн этгээдийн зүгээс үйлдсэн гэмт хэрэгт өндөр хэмжээний торгох ял оногдуулах (ялын дээд хэмжээг 800 сая болгох), гэмт хэргийг зөрчилд тооцохгүй байх, хохирол нөхөн төлүүлэх байдалд онцгой анхаарал хандуулах, давхар хариуцлагын зарчмыг ажиллуулах, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй төрийн зүгээс тууштай тэмцэх, экологийн цагдаагийн албыг өргөжүүлэх зэрэг эрх зүйн болон практик үүднээс боловсронгуй болгох асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа гадны орнуудын туршлагыг судлах, нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага тулгарчээ. Тухайлбал, АНУ-д байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тусгай байгууллага байгаа нь үр нөлөөгөө сүүлийн жилүүдэд өгч байна. Энэхүү байгууллага нь аюултай хог хаягдал, агаарын бохирдол, хөрсний ус, далайн хог хаягдал, байгальд хор учруулж буй шавьжийг устгах, мод хууль бусаар огтлох, ан агнах гээд олон салбарт ажиллаж байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй төрийн зүгээс хамтран тэмцэж байна.

Монгол Улс байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, байгаль орчны хохирлын үнэлгээний аргачлалыг хөгжүүлэх, хохирол нөхөн төлүүлэлтийг онцгой анхаарах шаардлагатайг эцэст нь цохон тэмдэглэж байна.

Санал, зөвлөмж

Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийсэн судалгаагаар илэрсэн үр дүнд суурилан дараах санал, зөвлөмжийг судлаачийн зүгээс дэвшүүлж байна.

1. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох:

- Байгаль орчны эсрэг 9 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагын субъект болгож байна. Хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэж гэмт хэргийн гаралт өндөр байгаа ч эрүүгийн хариуцлагын субъект биш тул ял завшсаар байна. Иймд цаашид Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн

9 гэмт хэрэгт хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээр нэмэлт өөрчлөлт оруулах;

- Байгаль орчны эсрэг гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхдээ оногдуулах ялын хэмжээг чангаруулах нь зүйтэй. Мөн Эрүүгийн хуулийн 9 дүгээр бүлэгт торгох ялын хэмжээг 800.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр буюу 800 сая төгрөгөөр торгох ялын санкцыг оруулах;

- Байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхдээ хохирол нөхөн төлсөн байдлыг онцгой харгалзан ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэн үзэх үндэслэлийг бий болгох;

- Дэлхийн улсууд болон Олон улсын жишгийг харгалзан байгаль орчны эсрэг зарим төрлийн гэмт хэргийг нэмж хуульчлах;

- Байгаль орчны гэмт хэргийн хохирлын үнэлгээг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох, хор уршигийг тооцох аргачлал бий болгох.

2. Практикт боловсронгуй болгох:

- Анхан шатны шүүхээс оногдуулсан шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхээс хөнгөрүүлэх хандлага байгааг анхааран үзэж хохирол төлөөгүй бол ялын дээд хэмжээнд ял оногдуулах талаар хуульчид анхаарах;

- Байгаль орчны гэмт хэргийг хянан шийдвэрлэх онцлог, хохирол, хор уршигийг шинжлэн судлах аргачлалын талаар хуульчдыг сургалтад хамруулах;

- Байгаль орчны гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, яллах, шүүн таслах чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэх, уялдуулах, хамтран ажиллах чиглэлийг сайжруулах;

- АНУ-ын жишгээр байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий тусгай байгууллагыг шинээр байгуулах

Ном зүй

1. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд, сургалтын гарын авлага

https://wwffasia.awsasse.ts.panda.org/downloads/20p10_wwf_hand_book_negdsen_.pdf

2. С.Сүхчулуун, Л.Отгондорж, "Байгаль орчны бохирдолтой холбоотой шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ", УБ., 2020 www.legaldata.mn

3. Ц.Цогт, "Байгаль орчныг хамгаалах асуудалд захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо", 2013 он. www.legaldata.mn

4. Б.Мэндбаяр, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, УБ., 2013 он

5. Ч.Зинамидарь, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын болон криминологийн асуудал, УБ., 2013 он
6. Баярсайхан Д. Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага. УБ., 2013.
7. Нарангэрэл С, Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж. УБ., 2017.
8. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги, УБ., 2018 он
9. Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал, УБ., 2010 он.
10. Одонгэрэл Б. "Эрүүгийн хариуцлага оногдуулах хуулийн этгээд, түүний төлөөллийн асуудал", Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2018 оны №4.
11. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
12. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012
13. Эрүүгийн хууль, 2015 он
14. Шүүн таслах ажиллагааны мэдээ, 2018-2022 он
15. Дэлхийн соёлын ба байгалийн өвийг хамгаалах тухай конвенц, 1972.11.16
16. Био-аюулгүй байдлын тухай Картагенийн Протокол
17. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1998)
18. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он
19. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008) Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолын хавсралт
20. Ус үндэсний хөтөлбөр (2010)
21. Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр (2011)
22. Ногоон хөгжлийн бодлого (2014); - Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025), (2015)
23. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030 (2016)
24. <https://www.fatf-gafi.org/en/publications/Environmentalcrime/Environmental-crime.html>
25. https://www.unodc.org/documents/NGO/EIA_Ecocrime_report_0908_final_draft_low.pdf
26. www.iucn.org
27. www.cbd.int
28. https://www.mne.mn/?page_id=454
29. http://portal.unesco.org/en/ev.php-URL_ID=13087&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html
30. АЛСЫН ХАРАА 2050 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО.pdf (nda.gov.mn)
31. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он.

СитиЗон төслийн хүрээнд:

- Багш, оюутнуудын дунд хувь хүний хөгжлийн сургалт, лекцүүд;
- Багш, оюутнуудын өдөрлөг, чөлөөт уулзалт, бүтээлийн үзэсгэлэн, урлаг, соёл, спортын арга хэмжээнүүд;
- Оюутан, төгсөгчид ажилд ороход, өөрийн бизнесээ эхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах, ажил горилогчдод тавигддаг, шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхөд нь туслах;
- Багш, оюутнуудын санаачлан боловсруулсан инновац, бизнесийн төслүүдийг шалгаруулж, жил бүр 1-3 төсөлд тус бүр 30 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт олгон, хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулна.
- Оюутнууд академик мэдлэгээс гадна практик дадлага, туршлагатай, хувь хүний хөгжлөөр өрсөлдөхүйц, бие даан ажиллаж, амьдрах чадвартай төгсөх ёстой.

